АШУҮИС-н Анагаахын суурь боловсролын 1-р дамжааны оюутнуудын Гистологи 1 хичээлийн дүнг улиралтай хамааруулан хийсэн үнэлгээ

С.Оюунгэрэл[1], Б.Энхзул[1], Б.Түмэнбаяр[1], Б.Наранбат[1], С.Чимэгсайхан[1], Д.Цолмон[1], Б.Сувдаа[1]

[1]АШУҮИС, БАС, Гистологийн тэнхим
Email: oyungerel.sodjamts@mnums.edu.mn, Утас:91990754

Түлхүүр үг:

Гистологи-1
АСБД 1
Дүн
Улирал

Товч утга: 2015-2017 оныг хүртэл Гистологи-1 хичээл нь 1-р дамжааны 2-р улиралд заагдахаа болиж 2017-одоог хүртэлх 3 жил 1-р дамжааны 1-р улиралд заагдаж байна. Аналитик судалгааны нэг агшингийн загвараар анагаахын суурь боловсролын дамжааны 2015 оноос хойшхи Гистологи-1 хичээлээр авсан 4297 оюутны дүнд MS excel программаар боловсруулалт хийж гүйцэтгэв. Нэгтгэсэн дүнгээр 1-р дамжааны 2 дох улиралд Гистологи-1 хичээл орж эхэлсэн 2015-2017 онуудад амжилт 85.9%, чанар 50.5%, (n=1478) 1-р дамжааны 1-р улиралд Гистологи-1 хичээл заагдаж эхэлсэн 2017-2020 онуудад амжилт 84.9%, чанар 43.5%, (n=2410) W үнэлэгдсэн буюу явцын оноогоо авч чадаагүй оюутан 2015-2017 онд 5%, 2017-2020 онуудад 12.1% байжээ.

Үндэслэл: 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн АШУҮИС-д 1-р дамжааны хөтөлбөр Блок болон кураци сургалтын системээс анагаахын суурь сургалтын системд шилжсэн бөгөөд энэ шилжилттэй холбоотойгоор 1 болон 2-р дамжаанд ерөнхий эрдмийн болон мэргэжлийн суурь хичээлүүд тохирох улиралд хуваарилагдан орж, 2-р дамжааны эцэст орсон хичээлүүдийн холимог тестийн шалгалтаар оюутнуудыг мэргэжил сонголтоор жагсаана.

Гистологи 1 хичээл нь агуулга ихтэй, кредит цаг өндөртэй оюутнуудад хими, физик, биологи, анатомийн хичээлийн сууринд заагддаг хийсвэр төсөөллийг бичил бэлдмэл дээр буулган бататгадаг өвөрмөц хичээл юм. 2015-2017 оныг хүртэл энэхүү хичээл нь дээрх ерөнхий эрдмийн болон мэргэжлийн хичээл орсны дараагаар буюу 1-р дамжааны 2-р улиралд заагддаг байж байгаад 2017 оноос одоог хүртэлх 3 жил 1-р дамжааны 1-р улиралд орж байна. Энэхүү хичээлийн орж эхлэх улирал, тухайн хичээлийн оюутнуудын үнэлгээ 2-н хоорондын харилцаа хамаарал судлагдаж байгаагүй билээ.

Зорилго: Гистологи-1 хичээлийн сүүлийн 5 жилийн дүнг 1-р дамжааны 2 дах улиралд заагдаж эхлэсэн буюу 2015-2017 онуудын хичээлийн жилийн дүнгийн дундажыг 2017-2020 онуудын 1-р дамжааны 1 дэх улиралд заагдаж эхлэсэн дүнтэй харьцуулан судлах

Судалгааны материал, арга зүй: Судалгааг аналитик судалгааны аргаар анагаахын суурь боловсролын дамжааны 2015 оноос хойшхи сүүлийн 5 жилийн Гистологи-1 хичээлээр авсан 4297 оюутны дүнд амжилт, чанар, W үнэлгээний эзлэх хувийг MS excel программаар боловсруулалт хийж гүйцэтгэв.

Үр дүн: Нэгтгэсэн дүнгээр 1-р дамжааны 2-р улиралд Гистологи-1 хичээл заагдаж эхэлсэн 2015-2017 онуудад амжилт 85.9%, чанар 50.5%, (n=1478) 1-р дамжааны 1-р улиралд Гистологи-1 хичээл заагдаж эхэлсэн 2017-2020 онуудад амжилт 84.9%, чанар 43.5%, (n=2410) W үнэлэгдсэн буюу явцын оноогоо авч чадаагүй оюутан 2015-2017 онд 5%, 2017-2020 онуудад 12.1% байжээ. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Гистологи-1 хичээлийн амжилт, чанарын үзүүлэлт

Үнэлгээ	2015-2017				2017-2020			
	n	%	Чанар	Амжилт	n	%	Чанар	Амжилт
A	278	19.6	85.9	50.5*	402	16.7	84.9	43.5*
B	469	33.1			647	26.8		
C	323	22.8			569	23.6		
D	200	14.1			427	17.7		
F	208	14.7			365	15.1		
W	78	5.0			331	12.1		
Нийт			1478				2410	

*p<0.001

Хэлцэмж: Бидний судлагаагаар 2015-2017 онуудаас 2017-2020 онуудад Гистологи-1 хичээлийн сурлагын чанар төдийлөн өөрчлөлт багатай байгаа ч сурлагын амжилт буурсан, W буюу хичээлийн явцийн дүнд

шалгалтанд доод оноонд хүрч чадаагүй оюутны тоо өссөн байгаа нь энэхүү хичээл заагддаг улиралтай холбоотой байх боломжтой ч нөлөөлж болох бусад хүчин зүйлийг олж илрүүлэх нь бас чухал юм. ОХУ, БНХАУ, ӨСУ болон Японы анагаахын сургуулиудад хичээл хөтөлбөрөөр ерөнхий эрдмийн хичээлүүд орсны дараагаар мэргэжлийн суурь хичээлүүд ордог байхад Америк, Европд хичээл сонголтоор ордог байна. Манай орны хувьд шинэ суурьшсан хөтөлбөрөөр явагдах учир энэ талын уялдуулсан судалгаа хомс байгаа бөгөөд шинэ суурьшсан хөтөлбөрын амжилт (Ж.Оргил нар 2019) ба хөтөлбөрийн судалгаа (М.Оюунцэцэг нар 2019) хийгдсэн байна.

Дүгнэлт:

1. 1-р дамжаанд хими, биологи, физик, анатоми-1 хичээлүүд орсоны дараах буюу 1-р дамжааны 2-р улиралд Гистологи-1 хичээл суусан оюутнуудын сурлагийн чанар 1-р улиралд орсон оюутнуудынхаас 7% илүү байна.
2. Мөн 1-р дамжааны 2-р улиралд Гистологи-1 хичээл дээр W үнэлэгдсэн оюутны тоо 1-р улиралд орсон оюутнуудынхаас 7.1% бага байна.

Ном зүй:

1. 2015-2020 оны Гистологи-1 хичээлийн дүнгийн хуудсууд
2. 174 Гистологи-1 хичээлийн хөтөлбөр
3. “Effect of Pre-Medical Education on Student Performance in a First-Year Medical School Curriculum, 2013”(PDF) Medical Science Educator • December 2013
4. "MCAT and GPAs for Applicants and Matriculants to U.S. Medical Schools by Primary Undergraduate Major, 2010" (PDF). AAMC.
5. Hartocollis, Anemona (10 July 2010), "Getting Into Medical School Without Hard Sciences", The New York Times
6. "Selection Factors". Harvard Medical School. Retrieved November 17, 2011.

Correlation between HISTOLOGY-1 course evaluation of Pre-Medical education on first-year student of MNUMS and course extending terms

Oyungerel.S[1],Enkhzul.B[1], Tumenbayar.B[1], Naranbat.B[1], Chimegsaikhan.S[1], Tsolmon.D[1], Suvdaa.B[1]

[1]Department of Histology, School of Biomedicine, MNUMS
Email: oyungerel.sodjamts@mnums.edu.mn, Tel:91990754

Histology-1, the course of Premdical education, had changing spring term 2015-2017 to fall 2017-until now. The research based on Histology-1 course evaluation of 4297 students throughout last 5 years and extending terms computing by MS Excel program via analytical research method. To sum up data, course evaluation success is 85.9%, quality is 50.5%, (n = 1478) for Pre-Medical education on first-year students with Histology-1 course on spring term during 2015-2017, and course evaluation success is 84.9%, quality 43.5%, (n = 2410) for same students with Histology-1 course on fall term during 2017-20206. W evalueted students who failed to Histology-1 are 5% in 2015-2017 and 12.1% in 2017-2020.

Key words: Histology-1, Premedical education, Course evaluation, Term